





**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЁС ЗҮЙН ХОРООНЫ
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх түвшин	Гүйцэтгэл
1	Нийт ажилтан, албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах	III улирал	Ёс зүйн талаарх шинэ мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.	<p>Ажилтан, албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр танхимын болон цахим сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: Танхимаар</p> <div style="display: flex; justify-content: space-between;"> <div style="width: 45%;">  </div> <div style="width: 45%;"> <ul style="list-style-type: none"> ❖ “Төрийн албан хаагчийн ёс зүй” сургалтыг ТАЗ-ийн Ажлын албаны Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ орж, 40 албан хаагч, ❖ “Ёс зүй, харилцаа хандлага” сургалтыг Клиникийн профессор, ахмад ажилтан С.Өлзийсайхан зааж 39 албан хаагч, ❖ “Зөв хандлагаас зөв харилцаа, утсаар харилцах урлаг” сургалтыг харилцааны багш Энхцогт зааж Дуудлага зохицуулах албаны 25 албан хаагч хамрагдлаа. </div> </div> <p>Цахимаар явагдсан сургалтууд:</p> <ul style="list-style-type: none"> ❖ ТАЗ-өөс зохион байгуулсан 7:4:10 “Төрийн албан хаагчийн ур чадварын түвшин, ёс зүйн үзэл, ёс суртахууны төлөвшил” цахим сургалтад 25 албан хаагчид хамрагдсан. Сургалтыг Удирдлагын академийн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Г.Жаргал удирдан явуулсан. <p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтууд:</p> <ul style="list-style-type: none"> ❖ 2022 онд зохион байгуулж буй эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох шалгалтын комиссын бүрэлдэхүүн болон мэргэжлийн Нийгэмлэг, Холбоо, Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, Анагаахын их, дээд сургууль төгсөгчдөөс мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх <div style="text-align: right;">  </div>

				<p>зөвшөөрлийн шалгалт авах комиссын гишүүдэд “Авлигаас урьдчилан сэргийлэх тухай” “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдэгдэл, тайлбар гаргах” сэдэвт сургалтыг АТГ-тай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж 32 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.</p> <ul style="list-style-type: none"> ❖ “Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тайлбар мэдэгдэл гаргах”, “Авлигын эсрэг хууль”-ийн тухай сургалтыг Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэс болон Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэстэй хамтран 6 сарын 15-20-ны өдрүүдэд зохион байгуулан ажилласан. ❖ ”2022-2023 оны хичээлийн жилийн үндсэн мэргэшлийн элсэлтийн шалгалтад бүртгүүлсэн их эмч нарт зориулсан авлига, ашиг сонирхлыг зөрчил, хуурамч мэдээллээс болгоомжлох, хохирогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээллийг ZOOM-ээр зохион байгуулж 236 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа. <p>Үр дүн: Нийт давхардсан тоогоор байгууллагын 179 албан хаагч болон 268 эмнэлгийн мэргэжилтэнд ёс зүйн соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгуулж, мэдлэг мэдээллээр хангалаа.</p>
2	Шинэ ажилтан, албан хаагчдад Байгууллагын ёс зүйн дүрэмтэй танилцуулах, ёс зүйн баталгаа гаргуулах	Жилийн турш	Байгууллагын ёс зүйн дүрэмтэй танилцсан, ёс зүйн баталгаа өгсөн байна.	<p>Төвийн Захирлын 2022 А/136 дугаар тушаалаар ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Хороог алба бүрийн мэргэжилтнүүдээс бүрдүүлсэн бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гэсэн 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Шинээр ажилд орсон албан хаагчдад Ёс зүйн дараах дүрэм журмыг уншуулж танилцуулан Ёс зүйн баталгаа гаргуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • ЭМХТ-ийн ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрэм • Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм • Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм • Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл <p>Үр дүн: Шинэ албан хаагчдад холбогдох дүрэм, журмыг танилцуулан, Ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Шинээр ажилд орсон албан хаагчдаас Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.</p>

3	“Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Ёс зүйтэй мэдээллэх нь” сургалт	III улирал	Ажилтан албан хаагчид хийж буй ажил, үүргээ олон нийтийн хэрэгслээр ёс зүйтэй мэдээллэх мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ёс зүйтэй мэдээ мэдээлэл өгөх талаар “Эрсдлийн үеийн харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгөх нь” сэдэвт сургалтыг “Цагаан үзэг” эрүүл мэндийн сэтгүүлчдийн холбоотой хамтран зохион байгуулж 19 албан хаагч хамрагдлаа. Үр дүн: Хэвлэл мэдээллийн хэрэслийн ёс зүйн талаар суралцсан.
4	Үйлчлүүлэгчдээс ирсэн санал гомдол, хүсэлт, сэтгэгдлийг бүртгэн дүгнэлт хийж эргэн мэдээлэх	IV улирал	Үйлчлүүлэгчдээс ирсэн гомдол, хүсэлтийг шийдвэрлэж эргэн мэдээлсэн байна.	Цахим хуудсаар ирүүлсэн асуултуудад холбогдох мэргэжилтнүүд болон олон нийттэй харилцах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн хариултыг цаг тухайд нь өгч ажиллаж байна. Өдөрт дунджаар 15-20 асуулт ирдэг. Цахим хуудасны comment хэсгээр ирж байгаа асуулт, шүүмж, санал хүсэлтүүдэд хариулж байна. Хариу өгсөн мэдээллийн тоо-1000 гаруй Залруулга мэдээлэл – 2 Тайлант хугацаанд зөрчил гаргасан 5 албан хаагчид ““Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр хаалттай сануулах”, 1 албан хаагчид “Нийт ажилтанд нь зарлах хэлбэрээр нээлттэй сануулах”, 1 албан хаагчид “Үндсэн цалинг гурван сарын хугацаагаар 20 хувиар бууруулах” сахилгын шийтгэл ногдуулсан. Үр дүн: Байгууллага, албан хаагчдын талаар гарсан мэдээллүүдэд үнэлгээ хийгдэн хариултуудыг авч тухай бүрд нь өгч байна.
5	“Албан харилцаа, албан хувцаслалт, харилцаа хандлага” сургалт	IV улирал	Байгууллага дээрх албан хувцаслалт жигдрэх боломж бүрдсэн байна.	“Байгууллагын үнэт зүйл, соёл, ёс суртахуун” сургалтыг АУ-ны доктор, профессор, ЭХГА, МАУА-ийн гишүүн, академич, ахмад ажилтан Ц.Содномпил зааж 50 албан хаагч хамрагдсан. Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг өндөржүүлэх, байгууллагын дотоод соёлыг хэвшүүлэх зорилгоор ЗСУА-наас “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” сэдэвт Ёс зүйн хичээл бэлтгэн байгууллагын дотоод сүлжээ болон ухаалаг дэлгэцээр нийтэд нэвтрүүлж мэдээлэл хүргэж байна. 

				<p>“Албан харилцаа, албан хувцаслалт, харилцаа хандлага” сэдвээр шторк, постер болон видео хичээлүүдийг бэлтгэн байгууллагын дотоод сүлжээгээр бүх албан хаагчдад байнга нэвтрүүлж ажиллаж байна.</p>  <p>Үр дүн: Албан хаагчдад ёс зүйн хэм хэмжээ, зарчмыг байнга сануулан ажилласнаар үйлчлүүлэгчдээс ёс зүйн холбоотой гомдол санал ирээгүй.</p>
6	Ёс зүйн хорооны үйл ажиллагааны тайланг холбогдох байгууллагад цаг тухай бүр тайлагнах	Бүтэн жилээр	Цаг тухай бүрт тайланг гарган холбогдох газарт хүргүүлсэн байна.	Ёс зүйн хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг ЭМС-ын 2017 оны А/256 дугаар тушаалаар батлагдсан “Дүрэм батлах тухай” тушаалын 1.9 дэх заалтын дагуу тайлагнаж, ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд хугацаанд нь хүргүүлсэн.
7	Нэмэлт үйл ажиллагаа	Бүтэн жилээр	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор Яст мэлхий, Туулай арга хэмжээг хэрэгжүүлж, хоцролтгүй хамт олон болох зорилго тавин ажиллаж байна. ЭМХТ-ийн нийт ажилтан албан хаагчдын дунд 2022 оны хамгийн эерэг харилцаа хандлагатай, ёс зүйтэй ажилтан албан хаагчийг тодруулах үйл ажиллагааг ёс зүйн хорооноос зохион байгуулав. Байгууллагынхаа ёс зүйтэй, зөв харилцаа хандлагатай албан хаагчийг шалгаруулах санал асуулгад оролцох урилгыг түгээж, 45 албан хаагч /нийт албан хаагчдын 60 хувь/ хамрагдав. Эдгээрээс төвийн 26 мэргэжилтэн дээр санал ирж, ЗСУА-ны 2 албан хаагч 9, 5 санал авч тэргүүлсэн.